

## **Монгол Улс, Бүгд Найрамдах Унгар Улсын хоорондын нийгмийн хамгааллын хэлэлцээр**

### **А. ХЭЛЭЛЦЭЭРИЙН АГУУЛГА**

Даатгуулагч Монгол улс болон Бүгд Найрамдах Унгар Улсад шимтгэл төлж ажилласан хугацаагаа нэгтгэн тооцож байж аль нэг талын хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгох бол энэ асуудлыг хариуцсан хоёр улсын байгууллагад өргөдөл гарган хугацаагаа нэгтгэн тооцуулж тэтгэвэр тогтоолгох боломжтой.

Хэрвээ даатгуулагч Монгол улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу, Бүгд Найрамдах Унгар Улсад тэтгэвэр тогтоолгох бол Бүгд Найрамдах Унгар Улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.

### **Б. ХЭЛЭЛЦЭЭРТ ХАМААРАХ ТЭТГЭВРИЙН ТӨРӨЛ**

Дараах төрлийн тэтгэврийг Монгол Улс болон БНУУ-ын хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

- Өндөр насны тэтгэвэр;
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр.

**Монгол Улсын иргэн дараах нөхцлийг хангасан тохиолдолд Бүгд Найрамдах Унгар Улсаас өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрх үүснэ:**

1. Бүгд Найрамдах Унгар Улсад ажиллаж, шимтгэл төлсөн байх  
Үүнд Бүгд Найрамдах Унгар Улсад их, дээд сургуульд суралцсан хугацаа орно.
  2. Бүгд Найрамдах Унгар Улсын хууль тогтоомжид заасан өндөр насны тэтгэврийн нас /65 нас/-нд хүрсэн байх.
  3. Бүгд Найрамдах Унгар Улсын хууль тогтоомжоор тогтоосон тэтгэврийн даатгалын шимтгэл төлж ажилласан байвал зохих хугацаа /15-20 жил/-г хангасан байх;
- **Шимтгэл төлж ажилласан байвал зохих хугацаанд Монгол Улсад шимтгэл төлсөн хугацааг оруулан тооцно.**